



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 1/127

Хэрлэн сум

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулж, дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", 29.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2015 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дүрмийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр эрхлэгч иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйддвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- |                                 |  |
|---------------------------------|--|
| Зөвлөлийн дарга:                | -Аймгийн Засаг даргын орлогч   |
| Зөвлөлийн нарийн бичгийн дарга: | -Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга  |
| Гишүүд:                         | -Мэргэжлийн хяналтын газрын дарга<br>-Эрүүл мэндийн газрын дарга<br>-Онцгой байдлын газрын дарга<br>-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга<br>-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга<br>-Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн<br>-Мэргэжлийн хяналтын газрын геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч<br>-Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга |

2//.

- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал
- Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
- Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
- Үйлдвэрчний хорооны дарга

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийг тооцож ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/124 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА